



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2019 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

**Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын дүнг хэлэлцсэн тухай**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалын хүрээнд Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын 2018 он, 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан, дүгнэлттэй танилцав.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр холбогдох байгууллагуудад өгөх зөвлөмжийг нэгээс тавдугаар хавсралтаар баталсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын Хүнс, хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хамтран ажиллахыг Увс аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д зөвлөсүгэй.

3. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газар /Д.Түмэндэмбэрэл/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Санхүү хөрөнгө оруулалтын газар /Б.Цогбадрах/, Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар /Д.Батмөнх/, Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар /Ц.Болорчулуун/ Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Д.Бадруун/, Тариалан эрхлэлтийг дэмжих сан /В.Үнэнбат/ Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Д.Төмөр-Очир/, Увс аймгийн Мал эмнэлгийн газар /М.Алтанцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

4. Зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлгийн ерөнхий газар /Д.Түмэндэмбэрэл/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Санхүү хөрөнгө оруулалтын газар /Б.Цогбадрах/, Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар /Д.Батмөнх/, Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар /Ц.Болорчулуун/ Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Д.Бадруун/, Тариалан эрхлэлтийг дэмжих сан /В.Үнэнбат/ Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Д.Төмөр-Очир/, Увс аймгийн Мал эмнэлгийн газар /М.Алтанцэцэг/-т тус тус даалгасугай.

5. Зөвлөмжийн хэрэгжилтийг хяналтад авч, дотоод аудитын хорооны хурлаар хагас, бүтэн жилээр хэлэлцүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ч.Тавинжил/-д үүрэг болгосугай.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ДОТООД  
АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА** **Ч.УЛААН**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## **УВС АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР**

1. Цөм сүргийн үржлийн төв нэг орон тоогоор ажиллаж байгаа нь үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул Цөм сүргийн бүтэц, зохион байгуулалт, харьяаллыг судлан үзэж, шийдвэрлэх,
2. Сумын Хөдөө аж ахуй болон Мал эмнэлгийн тасгийн орон тооны мэргэжилтний цалинг ТЗ-3 ангиллын хүрээнд тогтоосон асуудлыг судлаж, хууль, журмын хүрээнд шинэчлэн тогтоох
3. Жижиг, дунд үйлдвэрлэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгож, зээлийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгийн захиран зарцуулалт, төсөл хэрэгжүүлэлт, эргэн төлөлт, тайлагналттай холбоотой харилцаа, төрийн захиргаа болон нутгийн захиргааны байгууллагууд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, төслийн хэрэгжилт, хяналт тавих, үр дүнг үнэлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох

### **САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ**

1. Хөрөнгө оруулалт, худалдан авалтын гэрээт ажлын санхүүжилт олгох, гэрээ дүгнэсэн актын үндэслэлийг шалгахдаа орон нутгаас ирүүлж буй анхан шатны баримт, гүйцэтгэгч байгууллагын баримтыг үндэслэж үлдэгдэл санхүүжилтийг шилжүүлж байх,

### **МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ**

1. Ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажилд хангалттай ахиц дэвшил гарахгүй байна. Учир нь нэг малын ээмэг 1100 төгрөг, нэг малын ангилалтын зардал 850 төгрөг байгаа нь малчдыг энэ арга хэмжээнд малаа хамруулах сонирхлыг бууруулж байна. Нөгөө талаас малын ээмэг нийлүүлэгч байгууллага нь ээмэгний мөнгийг урьдчилж төлөх шаардлага тавьдаг нь төсвийн байгууллагад дарамт болж байна. Бодлогын түвшинд шийдвэр гаргах,
2. Малын бүртгэлийн программд 2011-2013 оны хугацаанд оруулсан малын мэдээлэл байгаа ч хасалт хийгддэггүй тул бүртгэлтэй малын тоон мэдээлэл бодитой эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна. Бүртгэлийн программ ашиглалтын шаардлага хангах эсэхэд үнэлгээ, дүгнэлт хийх,
3. ХХААХҮ-ийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулж байгаа болон аймгийн Засаг даргатай байгуулж байгаа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдах Мал аж ахуйн талаар хэрэгжүүлэх арга хэмжээний санал, төслийг урьдчилан ХХААГ-т танилцуулж санал авах, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд арга хэмжээний зардал, хөрөнгө оруулалтыг тусгах боломжийг бүрдүүлэх,

4. Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээний санхүүжилтыг технологийн хугацаанаас өмнө орон нутагт олгох, ажлыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх,

5. 2018 онд тараагдсан мал угаалын ванны үлдэгдэл (225 ширхэг)-ийг орон нутагт нийлүүлэх ажлыг яаралтай зохион байгуулах,

#### ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ:

1. Тус аймаг нь баруун бүсийн аймгуудаас үр тариа хамгийн ихээр тариалдаг. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн салбаргүйгээс ХХААГ дээр ургамал хамгааллын бодис, шатахууны гэрээ байгуулдаг, мөн жимс жимсгэнэ, хүнсний ногооны тариалалт ихтэй зэргийг харгалзан Газар тариалангийн нэг мэргэжилтний орон тоо нэмж ажиллуулах,

#### ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

1. Төрийн албан хаагчдын ХШҮ, тайлагналттай холбоотой арга зүйн удирдлагаар хангаж ажиллах,

#### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭСТ:

1. Хөдөө орон нутгийн мэргэжилтнүүдийг гадаад улсын туршлага судлах арга хэмжээнд хамруулах, төсөл, хөтөлбөрийн хүрээнд орон нутагт сургалт зохион байгуулах, оролцоог хангахад анхаарч ажиллах,

2. Гадаадын төслүүд болон салбарт хэрэгжиж байгаа сангуудын хөрөнгө оруулалтын асуудалд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцоо хангалтгүй байна. Иймд гадаадын төсөл хөтөлбөрөөс орон нутагт хэрэгжүүлж байгаа ажлуудад орон нутгийн байгууллага, санхүүжүүлэгч, ашиг хүртэгч нарын хооронд гурвалсан гэрээ байгуулж, тус бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхойлон ажиллаж хэвшүүлэх,

3. Монгол, Францын Засгийн газар хоорондын 2004 онд байгуулсан хэлэлцээрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийн талаар ХШҮДАГ-т тайлан ирүүлэх.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

## **УВС АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Увс аймгийн Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ**

1. Аймгийн мал эмнэлгийн газрын даргын сонгон шалгаруулалтыг зарлах, албажуулах,
2. Аймгийн ХХААГ болон Мал эмнэлгийн газрын хөрөнгө хуваарилах тогтоолыг яаралтай албажуулах талаар ТӨБХЗГ-тай хамтран ажиллах,
3. Сумын ХХААТ, МЭТ-ийн хөрөнгө хуваарилах ажлыг хэрэгжүүлэх,
4. Аймгийн Мал эмнэлгийн газрын байрны газар, ажлын байрны асуудлыг яаралтай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, Мал эмнэлгийн газрын ажлын байр шаардлагад нийцээгүй. 48 квм орчим талбай бүхий оффисын өрөөнд 10 гаруй мэргэжилтэн сууж ажиллаж байна.
5. Мал эмнэлгийн газрын дутуу боловсон хүчний томилгоог Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн томилох,
6. Аймгийн ХХААГ болон Мал эмнэлгийн газрын хөрөнгө хуваарилах тогтоол албажаагүй байгаа ба сумдын ХХААТ, МЭТ-ийн хөрөнгө хуваарилах ажил огт хийгдээгүй байгаа тул ажлыг эрчимжүүлэх талаар ажиллах, Мал эмнэлгийн тасгийн ажлын байраар хангах асуудлаар орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллах, нэгдсэн ойлголттой болгох,
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлж байгаа вакцин эм, биобэлдмэл болон бусад материалын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах,
8. Гурвалсан гэрээг дүгнэх талаар орон нутгийн мал эмнэлгийн болон холбогдох бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах,
9. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт хангах хүрээнд боловсруулж байгаа аймгийн мал эмнэлгийн газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг дахин хянаж үзэх,
10. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийн хяналт хангалттай биш, дархлаажуулалтын үйлчилгээний хөлсний материалын бүрдэл, санхүүгийн тооцоонд тавих хяналт туйлын хангалтгүй байна. Гүйцэтгэлээр бүрдүүлсэн материалд хяналт, тооцоолол хийдэггүй зөвхөн вакцины хуваарь, хамруулах малын тоог баталсан баримтыг үндэслэн үйлчилгээний хөлсийг олгож байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байгаа тул хяналтын оновчтой механизмыг яаралтай боловсруулж, хэрэгжилтийг хангах,
11. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг мал, амьтны өвчний голомт, тархалт, тархвар зүйн нөхцөл байдалд үндэслэх бус мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд вакциныг хүртээх маягаар жигд хуваарилах байдал давтагдсаар байгаа байдалд дүгнэлт хийж, эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилан мал эмнэлгийн олон талт үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх,

12. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.12 дахь заалтад байгаа “Гурвалсан гэрээний загвар” батлах асуулал нь Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн төвшинг үнэлэх журам”-тай зөрчилдөх байдал үүсч байгаа тул тогтолцооны хувьд босоо удирдлагатай байгууллага үүнийг анхаарч хуулийн хэрэгжилтэд анхаарах,

13. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг дагалдан гарсан дүрэм, журам, зааврыг судлах, хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна. Мал эмнэлгийн газар, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд үндсэндээ шинэ хууль эрх зүйн хүрээнд батлагдан гарсан бичиг баримтыг уншиж судлаагүй, сурталчлан таниулах ажлын хэрэгжүүлж чадаагүй байна.

14. Мал эмнэлгийн нэгжийн малын эмч нарын насжилт өндөр болсонтой холбоотойгоор мал эмнэлгийн үйлчилгээг малчдад хүргэх, мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудал хүндрэлтэй болж байгаа тул орон нутагт залуу боловсон хүчин ажиллах боломж нөхцөл бүрдүүлэх, хөтөлбөр төсөл боловсруулан хэрэгжүүлэх,

15. Биокомбинат УТҮГ-ын вакцины үйлдвэрлэл, орон нутагтнийлүүлэлт зэрэгт анхаарах, Цусан халдвар болон Сохор доголоос сэргийлэх вакцинуудын чанарын асуудлыг тусгайлан судалж, дүгнэлт гаргах,

16. Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаа “Бүх зүйлийг дээрээс гэсэн хандлагыг орон нутгийн мал эмнэлгийн байгууллагуудад бий болгосон” нь ажил санаачлан хэрэгжүүлэх боломжийг үгүй болгож байна. Хандлагыг өөрчлөх, хүн төвтэй хөгжлийг бий болгох,

17. Мал эмнэлгийн лабораторийн мэргэжилтнүүдийн /нарийн мэргэшил/ тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах шаардлагатай байна.

18. Мал эмнэлгийн газрын бүтцийг дахин авч үзэх, ингэхдээ молекул биологийн шинжээчийн асуудлыг авч үзэх,

19. Мал эмнэлгийн боловсон хүчний сургалтыг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон дагалдан гарсан дүрэм, журмын хүрээнд зохион байгуулах,

20. Мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн хуучин гэрчилгээг татан аваагүй, гэрчилгээний үнийн асуудлыг МЭЕГ-аас нэгдсэн байдлаар тогтоож өгөөгүй зэрэг хүндрэл орон нутагт тулгарч байгаагаас гадна бичилтийн хувьд шинээр хэвлүүлсэн гэрчилгээнд байгаа ойлгомжгүй зүйлс дээр орон нутгийн мал эмнэлгийн байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх,

21. Сум, орон нутгийн зарим удирдлагууд мал эмнэлгийн байгууллага босоо тогтолцоотой болсон тул мал эмнэлгийн тасаг, нэгжийн үйл ажиллагаа бидэнд хамааралгүй гэсэн ойлголттой болсон байгаа тул аймаг, нийслэлийн Засаг дарга нартай “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар болон Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг, нэгжийн талаар харилцан ойлголцлыг бий болгох арга хэмжээг сайтар зохион байгуулах,

## ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНД

1. 2012-2013 онд бага оврын трактор зээлээр авсан 38 зээлдэгчийн гэрээ Увс аймгийн ХХААГ-т байхгүйг хүргүүлэх. Чацарганын болон Бага оврын тракторын зээлийн эргэн төлөлтийг сайжруулахыг,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

## **УВС АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД**

1. Аймгийн хэмжээнд мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хүлээж байгаа мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн энэ чиглэлийн үйл ажиллагаанд шаардагдах эм урвалж, цомгийг аймаг, орон нутгийн төсөвт суулгах, лабораторийн шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

2. Сум, орон нутгийн удирдлагуудад мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, дагалдан гарсан эрх зүйн баримт бичгийг сурталчлан таниулах, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалтай холбогдох мал эмнэлгийн арга хэмжээнд тэдний оролцоог хангах талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах,

3. Мал эмнэлгийн газрын албан хаагчдын ажлын байрны газрын асуудлыг шийдвэрлэх,

Увс аймгийн хэмжээнд мал үржүүлэг, технологийн нэгж шинээр байгуулах, мал зүйч бэлтгэх асуудлыг орон нутгийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

## **УВС АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **УВС АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАРТ**

1. МАА-н чиглэлээр "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого", "Монгол мал", "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх хүрээнд аймаг, орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг яаралтай батлан, хэрэгжилтийг хангах,
2. Мал аж ахуйн мэргэжилтэн, мал зүйч нар орон нутагт дутагдалтай байгаа тул орон нутгийн хэмжээнд мэргэжилтэн бэлтгэх бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, ,
3. Мал зүйч мэргэжилтний ажлын байр, албан тушаалд мэргэжлийн мал зүйч ажиллуулах,
4. ХХААХҮ-ийн сайдтай ХХААГ-ын даргын байгуулж байгаа гэрээний төслийг урьдчилж ХХААГ-т танилцуулдаггүй, оны эхээр батлагддаг, орон нутгаас тухайн чиглэлийн арга хэмжээнд мөнгө хөрөнгө төсөвлөдөггүй зэргээс шалтгаалан төсөв, хөрөнгөгүй ажлыг хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна
5. Орон нутгийн хэмжээнд мал аж ахуйн чиглэлийн ажил үүрэгтэй холбоотой орон нутгийн суурь нөхцөл, судалгааг сайжруулах,
6. Ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн ажилд хангалттай ахиц дэвшил гарахгүй байна. Учир нь нэг малын ээмэг 1100 төгрөг, нэг малын ангилалтын зардал 850 төгрөг байгаа нь малчдыг энэ арга хэмжээнд малаа хамруулах сонирхлыг бууруулж байна. Нөгөө талаас малын ээмэг нийлүүлэгч байгууллага нь ээмэгний мөнгийг урьдчилж төлөх шаардлага тавьдаг нь төсвийн байгууллагад дарамт болж байна.
7. Малын бүртгэлийн программд 2011-2013 оны хугацаанд оруулсан малын мэдээлэл байгаа ч хасалт хийгддэггүй тул бүртгэлтэй малын тоон мэдээлэл бодитой эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна.
8. Төрийн хоёр байгууллага (ХХААГ, МЭГ) нэг байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хөрөнгө хуваарилалт хийж, байрны асуудлыг шийдвэрлэсэн ч албан ажлын шаардлагад нийцээгүй байранд үйл ажиллагаа явуулсан хэвээр байна. Нөгөө талаас байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдийн хоорондын ойлголцол сайнгүй байна.
9. Албан хаагчдын ажилласан жил, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг зөв тогтоож, олгох
10. Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын батлан мөрдүүлж байгаа “Хөдөлмөрийн дотоод журам” нь Хөдөлмөрийн дотоод журамд хуулиас давсан зарим зохицуулалтыг тусгасан байгаа тул шинэчлэн батлах,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын тавдугаар хавсралт

## **УВС АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **УВС АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАРТ:**

1. Мал эмнэлгийн газрын төрийн захиргааны 6, мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн 16 орон тооны ажлын байрыг “Төрийн албаны тухай” хуульд нийцүүлэн сонгон шалгаруулалт зарлаж, томилгоог баталгаажуулах,
2. Мал эмнэлгийн газрын даргын батлан мөрдүүлж байгаа “Хөдөлмөрийн дотоод журам” нь Хөдөлмөрийн дотоод журамд хуулиас давсан зарим зохицуулалтыг тусгасан байгаа тул шинэчлэн батлах,
3. Өөрийн орлогыг данс бүртгэлд бүрэн төвлөрүүлэх
4. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын болон холбогдох алба, нэгжийн стратеги төлөвлөгөөг яаралтай баталж, дараагийн шатны бичиг баримтыг стратегид суурилан боловсруулах, хэрэгжилтийг хангах,
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн оношлуур, эм урвалж, бусад зүйлсийн ашиглалт, хамгаалалтад тавих санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтыг сайжруулах,
6. Мал эмнэлгийн тасагтай гүйцэтгэлийн гэрээ, Сумын Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн хооронд Гурвалсан гэрээ байгуулж ажиллах, гэрээг жил бүрийн эцэст дүгнэх,
7. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг дагалдан гарсан дүрэм, журам, зааврыг мал эмнэлгийн газар болон тасаг, нэгжийн мэргэжилтнүүдэд судлуулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах,
8. Орон нутагт малын эмч нарын залуу үеийнхэн ажиллах сонирхол төрүүлэхүйц боловсон хүчний бодлого, дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх,
9. Мал, амьтны өвчний тархвар зүйн нөхцөл байдал, эрсдэлийн дүн шинжилгээнд суурилан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, өвчингүй, тайван байдлыг нотлох зэрэг мал эмнэлгийн олон талт арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,